



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2018. 01.24 № 05

Асуулга тавих тухай

Дэлхийн зах зээл дээрх нефть бүтээгдэхүүн болон валютын ханшийн хэлбэлзэл зэргээс шалтгаалж манай оронд жижиглэн худалдаагаар борлуулагдаж буй автобензин, дизель түлшний үнэ нэмэгдсээр ирлээ. Автобензин, дизель түлшний үнэ ханш тодорхой хэмжээнд нэмэгдэхэд түүнийг дагаад нийтийн тээвэр, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл бий болж, иргэдийн амьдралд дарамт учруулдаг байдал нэгэнт хэвшин тогтжээ.

Сүүлийн үед шатахуун импортлогч компаниуд нөөц дуусч байгаа гэх нэрийдлээр бүх төрлийн автобензин, дизель түлшнийхээ худалдаанд хязгаарлалт хийж эхэллээ. Гэтэл салбарын яамнаас өгч буй мэдээллээр нефтийн бүтээгдэхүүний хомсдол үүсэх нөхцөл байдал бий болоогүй байна. Өнөөдрийн байдлаар хамгийн өргөн хэрэглээний АИ92 автобензин ихэнх шатахуун түгээх станцуудаар хязгаарлагдмал зарагдаж байна. Мөн автобензин, дизелийн түлшний үнэ 50-150 төгрөгөөр нэмэгдлээ.

Энэ нь алслагдсан бүс нутаг болон төвийн бүс нутгийн шатахууны үнийн зөрүү ихсэх эрсдэл дагуулж байна. Нийслэлээс 1500-2000 км алслагдсан нутгуудад амьдарч байгаа иргэд төвийн бүсийн иргэдтэй адил цалин, ижил халамж хүртэж байгаа хэрнээ хэрэглэж байгаа автобензин, дизель түлш, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ нь төвийн бүсээс харьцангуй өндөр байна. Тухайлбал, Ховд аймагт АИ92 автобензин 230 төгрөгөөр, АИ80 автобензин 280 төгрөгөөр, дизель түлш 80 төгрөгөөр тус тус Улаанбаатараас үнэтэй байна. Энэхүү үнийн зөрүүтэй нөхцөл байдал нь алслагдсан бүсэд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжихөд тээг саад болж, иргэдийн Улаанбаатар хот, төвийн бүсийг чиглэсэн их нүүдлийг хөхиүлэн дэмжсээр ирлээ.

Миний бие 2010 оноос хойш төвийн бүс болон алслагдсан бүс нутгийн бензин шатахууны үнийг ижил түвшинд байлгах асуудлаар удаа дараа асуулт, асуулга тавьж, шахаж шаардаж ажилласны үр дүнд 2015 онд баруун хилээр орж ирж буй автобензин, дизелийн түлшний гаалийн болон онцгой албан татварыг чөлөөлж баруун бүс нутгийн шатахууны үнэ литр тутамд 180-400 төгрөгөөр буурч Улаанбаатарын үнэтэй ойролцоо болж байсан. 2015 оноос хойш Цагааннуур, Ярант, Гашуунсухайт, Шивээхүрэн зэрэг баруун бүсийн боомтуудаар импортоор орж ирж байгаа автобензин, дизелийн түлшний татварт өөрчлөлт ороогүй, 0 хувийн татвартай байсан. Харин Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг, Эрээнцав зэрэг төвийн болон, зүүн бүсийн боомтоор орж ирж байгаа автобензин, дизелийн түлшний татвар 2016 онд 3 удаа буурч, 2017 онд 2 удаа нэмэгдсэн байна. Гэтэл татварын өөрчлөлт ороогүй баруун бүсэд шатахууны үнэ нэмэгдэж, төвийн бүстэй

харьцуулахад үнийн зөрүү ихэссээр байна. Төрийн бодлогын залгамж чанар үргэлжлэх учиртай. Цаашид нефть бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэхгүй байх, улсын хэмжээнд ижил үнэтэй байлгах талаар дорвитой арга хэмжээ авахгүй бол эдийн засаг дөнгөж сэргэж байгаа энэ үед ард иргэдийн амьдралд хүнд дарамт, хөшүүн дөнгө болох нөхцөл үүслээ.


Иймээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд шатахууны өнөөгийн нөөц, үнийн өсөлт хэлбэлзэл, цаашид авах арга хэмжээтэй холбоотой дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын хэмжээнд ойрын өдрүүдэд шатахууны хомсдол бий болж, шатахуун түгээх станцуудад дараалал үүсэж, иргэдийн дунд үл ойлгогдох нөхцөл байдал бий болоод байна. Иймд манай улсад шатахууны нөөц яг ямар хэмжээтэй байгаа, хомсдол үүсэх бодитой шалтгаан бий эсэх талаар,
2. Шатахууны үнийн өөрчлөлт өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэд хэрхэн нөлөөлдөг талаарх судалгаа, (Тухайлбал, литр тутамд 100 төгрөгөөр нэмэгдэхэд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ хэдэн төгрөгөөр нэмэгдэх талаар)
3. Алслагдсан бүс нутгийн иргэдийн амьдрах нөхцөл боломжийг сайжруулах, төвийн бүстэй ойролцоо болгох нь одоогийн үүсээд байгаа төвлөрөл, түүнээс үүдэлтэй агаар, хөрсний бохирдол зэрэг олон асуудлыг шийдвэрлэх, сэргийлэх гарц гэж үзэж байна. Тэр дундаа алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүс нутагтай ойролцоо хэмжээнд байлгах шаардлагатай. Үүнийг шийдвэрлэхэд ямар шийдэл, боломж байгаа талаар,
4. Газрын тос боловсруулах үйлдвэр хэзээ ашиглалтад орж, нефтийн бүрэн хараат байдалд нэрвэгдэж буй энэ эрсдлээс хэрхэн сэргийлэх талаар Засгийн газар ямар бодлого баримталж, хэрэгжүүлж байна вэ? Газрын тосоо түүхийгээр нь гадагш нь зөөж, өөрсдөө өндөр үнэтэй шатахуун авдаг өнөөгийн гажуудлыг хэзээ хэрхэн засах вэ?
5. Автобензин, дизелийн түлшний үнэ нэмэгдэж, түүнийг дагаад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, үндэсний томоохон баяр Цагаан сарын өмнө үнэ ханш өсөж байгаа нь ард иргэдийн дунд бухимдал үүсгээд байна. Иймд автобензин, дизелийн түлшний үнэ нэмэгдэх бодит шалтгаан байгаа эсэх, үндэслэлтэйгээр үнэ нэмэгдэж байгаа бол шатахуун импортлогчидтой үр дүнтэй хамтран ажиллах, яаралтай хэлэлцээрт орох, гарц шийдэл олох, үндэслэлгүйгээр үнээ нэмж байгаа бол хариуцлага тооцох шаардлагатай гэж үзэж байна. Энэ бүхний эцэст иргэд хохирч болохгүйг хатуу санах хэрэгтэй.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хугацаанд ирүүлж, улмаар Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ